

ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА, ЦАЛИН ХӨЛСНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА Б.НАРАНГАРАВЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл -ийн хувь
1. ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЦАЛИН ХӨЛСНИЙ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН ГУРВАН ТАЛТ БОЛОН БУСАД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАХ							
1.	Арга хэмжээ 1.1 Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангана.	ХЭДС 1.7 тэрбум төгрөг	Шинэчлэн боловсруулсан баримт бичиг /тоо/	0	2	“Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр”-ийг боловсруулан Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар 23-ны 03 дугаар тогтоолоор батлуулсан. 2024 оны 4 дүгээр улиралд тус хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд 2025 оны 01 дүгээр сард хэрэгжилтийн дүнг нэгтгэв. Өнгөрсөн онд хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээнд 13 аймаг, 7 дүүргийн 82 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан байна. -Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн дотоод 563 дүрэм, журам, тушаал, холбогдох бусад баримт бичгийг боловсруулсан; -Сургалтын арга хэмжээнд 225 аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч, хүний нөөцийн 1253 хүн хамрагдсан байна. Зөвлөх үйлчилгээнд барилга, тавилга, оёдол болон хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдсан байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор “Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамжийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/111 дүгээр тушаалаар	100%

						батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг ХХҮЕГ-т хэргүүлэв. Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2025 оны төсвийн хуваар уг хөтөлбөрийн зардал 1,7 тэрбум төгрөг тусган батлагдсан.	
2.	Арга хэмжээ 1.2 Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж боловсруулж батлуулна.	-	Сайдын тушаал	0	1	“Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамжийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/111 дүгээр тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2025 оны 05 дугаар сарын 22-ны 01/1690 албан бичгээр хүргүүлсэн. Мөн ХХҮЕГ-аас 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /хэлтэс/-т хүргүүлэн хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Мэргэшсэн зөвлөх”-үүдийг бэлтгэх сургалтыг 2024 оны 5, 11 дүгээр сард 2 удаа зохион байгуулж нийт 63 “Мэргэшсэн зөвлөх” бэлтгэв. 2025 оны 06 дугаар сарын 12-14-нд 3 дахь удаагийн сургалтыг зохион байгуулж байгаа бөгөөд сургалтад 5 аймаг, Улаанбаатар хотоос хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал, хуульч, эрх зүйч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон бусад чиглэлээр мэргэшсэн нийт 24 шилдэг мэргэшсэн хүмүүс цуглан сургалтад хамрагдан мэдлэг, мэдээллээ шинэчлэн “Мэргэшсэн зөвлөх” гэрчилгээ гардлаа. /https://www.facebook.com/mlsp.gov.mn/posts/pfbid023CUsnT5EV1bJRT2KK8N7zfBqAhnqBixZJ3yqGPS48X1EacsjKVHEZdqz68pXUDAtI?rdid=lmzOMY3l8T7P8IGf#/	100%
3.	Арга хэмжээ 1.3 Жаргалтай өвөл буюу Harry January хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулна.	-	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын 2025 оны 10 дугаар хуралдааны тэмдэглэл	1	Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэл, 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлээр хүйтний улиралд ажлын цагийн зохицуулалт хийхтэй уялдуулан “Harry January” арга хэмжээг өвлийн аялал жуулчлал, гэр бүлд суурилсан байдлаар жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрөөс дараа оны 01 дүгээр сарын 31-ний хооронд	95%

						<p>зохион байгуулах хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахыг даалгасан.</p> <p>Энэ хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/92 дугаар тушаалаар Эрүүл мэндийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Боловсролын яам, Зам, тээврийн яам, Эрчим хүчний яам, Сангийн яам болон зарим судлаачдаас бүрдсэн салбар дундын ажлын хэсэг байгуулагдан ажиллалаа.</p> <p>“HAPPY JANUARY” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр УИХ дахь МАН-ын бүлэгт танилцуулсан.</p> <p>Түүнчлэн “HAPPY JANUARY” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай нэгдсэн төлөвлөгөө батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 01/1516 тоот албан бичгээр санал аван нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхэд бэлэн болсон.</p>	
4.	Арга хэмжээ 1.4 Аж ахуйн нэгж, байгууллагад зайнаас, цахимаар ажиллах хөдөлмөрийн дотоод журам боловсруулах аргачлал, зөвлөмжийг боловсруулан батлуулна.	үйл ажиллагааны зардал	Боловсруулсан баримт бичиг /тоо/	0	1	<p>“Гэр бүлд ээлтэй хөдөлмөрийн харилцаа ажлын байр” судалгаа /Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3/ хийх, төрийн албан хаагч, аж ахуйн нэгж, байгууллагад зайнаас, цахимаар ажиллах журам, хөдөлмөрийн дотоод журам боловсруулах аргачлал, зөвлөмжийг боловсруулан батлуулах ажлыг 2025 оны 07-10 дугаар сард НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран зохион байгуулахаар төлөвлөөд байна.</p>	90%

5.	Арга хэмжээ 1.5 Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр болон хөдөлмөрийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах хүрээнд холбогдох сургалт зохион байгуулна.	ХЭДС	Зохион байгуулсан сургалтын тоо		<p>Сургалтын тоо, хамрагдсан салбар, хүний тоо</p> <p>-Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “БҮСЧИЛСЭЭГ ХӨГЖИЛ ТӨРИЙН АЛБАНЫ МАНЛАЙЛАЛ” бүсийн чуулганы бүх бүсэд “Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэглээ” сэдвээр илтгэл мэдээлэл боловсруулан танилцуулав.</p> <p>-Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарах асуудал, цаашдын зорилго” , УИХ-ын Байнгын хороод, хүсэлт ирүүлсэн ААНБ, МҮЭХ зэрэг 7 байгууллагад мэдээлэл хийж хуулийг олон нийтэд таниулах үйл ажиллагааг зохион байгуулж байна.</p> <p>- “Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 12-14-нд “Мэргэшсэн зөвлөх” бэлтгэх ”3 дахь удаагийн сургалтыг зохион байгуулав. Сургалтад 5 аймаг, Улаанбаатар хотоос хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал, хуульч, эрх зүйч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон бусад чиглэлээр мэргэшсэн нийт 24 шилдэг мэргэшсэн хүмүүс хамрагдан мэдлэг, мэдээллээ шинэчлэн “Мэргэшсэн зөвлөх” гэрчилгээ олгов.</p>	100%
----	--	------	---------------------------------	--	--	------

6.	<p>Арга хэмжээ 1.6 Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотой тооцоо, судалгааг хийж, холбогдох тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.</p>	үйл ажилл агааны зардал	Тооцоо, танилцуулга	0	1	<p>Өнгөрсөн хугацаанд төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримталж ирсэн бөгөөд төрийн албан хаагчийн цалин хөлсний бодлогын шинэчлэлийн хүрээнд 2022 оноос эхлэн цалингийн шатлалыг хялбаршуулахад чиглэсэн арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж байна. Уг бодлогыг үргэлжлүүлж Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дунджаар 40 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Мөн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Монгол Улсын 2025 оны улсын төсөвт тусгасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын үндсэн цалинг 6 хувиар нэмэгдүүлэн тогтоосон.</p> <p>Мөн Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хорооны албан хаагчдын цалин хөлсийг адил ангилал, зэрэглэлд хамаарах байгууллагуудын албан тушаалын цалинтэй нэгтгэж, нэмэгдүүлэн тогтоосон. Мөн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн цалингийн хэмжээг Засгийн газрын 2025 оны 229 дүгээр тогтоолоор шинэчлэн тогтоосон.</p> <p>- Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 161 дүгээр тогтоолын хавсралтаар “Зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагын алба хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ыг батлуулсан.</p> <p>Тогтоолын төсөл батлагдсанаар батлан хамгаалах, зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн цэргийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 5 хувиар нэмэгдүүлэн I зэрэгт 20 хувь, II зэрэгт 15 хувь, III зэрэгт 10 хувиар шинэчлэн олгох бөгөөд уг нэмэгдлийг олгоход 2.3 тэрбум төгрөг зарцуулна.</p> <p>- Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн “Журам батлах тухай” 266 дугаар тогтоолоор “Шүүхийн</p>	100%
----	---	-------------------------	---------------------	---	---	---	------

					<p>шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам"-ыг батлуулсан.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын офицер, ахлагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг цэргийн байгууллагуудын мөрдөж байгаа хувь хэмжээтэй адилтган мэргэшлийн III зэрэгт 10, II зэрэгт 15, I зэрэгт 20 хувиар тооцож, албан тушаалын үндсэн цалингаас сар бүр бодож олгохоор зохицуулсан.</p> <p>Ингэснээр алба хаагчид өөрийгөө тал бүрээр хөгжүүлэх идэвх, санаачилга нэмэгдэх, бие бялдрын бэлтгэлжилт, мэдлэг боловсрол дээшлэх чухал ач холбогдолтой юм.</p> <p>Тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.</p> <p>- Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллыг сайд, сангийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "Шалгуур үзүүлэлт батлах тухай" А/136, А/80, А/69 дүгээр хамтарсан тушаалаар "Насан туршийн суралцахуйн төвийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийг батлуулсан.</p> <p>Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн "Журам батлах тухай" 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p>	
--	--	--	--	--	--	--

7.	Арга хэмжээ 1.7 Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөлөлд төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр тусгах арга хэмжээний тооцоо, судалгааг хийж Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлнэ.	үйл ажилл агааны зардал	Тооцоо, танилцуулг а	0	1	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтод “Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг нэгдсэн зарчим, бодлого, арга зүйгээр шинэчлэн тодорхойлох”, “Төрийн албан хаагчийн нэр хүндийг дээшлүүлж, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах зохистой тогтолцоог төлөвшүүлэх” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.7-д “Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлнэ.” гэж тус тус тусгагдсан. Уг зорилт арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримтлан 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг 8 хувиар нэмэгдүүлэхэд 2026 онд 560.0 тэрбум төгрөг нэмж шаардагдахаар байна. Мөн төрийн захиргааны албан хаагчдын цалинг нэг сүлжээнд нэгтгэн тогтооход 78.6 тэрбум төгрөг, зарим албан тушаалын ангилал, зэрэглэлийг оновчтой болгоход 15.3 тэрбум төгрөг тус тус нэмж шаардагдахаар тооцлоо. Дээрх байдлаар төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, ангилал зэрэглэл, цалингийн сүлжээг оновчтой болгох арга хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхэд 2026 онд нийт 653.9 тэрбум төгрөг нэмж шаардагдахаар байна. Холбогдох тооцоо, судалгааг ЭЗХЯ, СЯ-нд хүргүүлээд байна.	100%
8.	Арга хэмжээ 1.8 Ажилтны ажил, амралтын цаг, цалин хөлстэй холбоотой тогтоол шийдвэрийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагын хүний нөөц болон	үйл ажилл агааны зардал	Танилцуулг а, мэдээлэл, шийдвэрий н төсөл	0	1	Зуны цагийн тоололд шилжих буюу “цаг урагшлуулах” зохицуулалтын тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан холбогдох яамдаас саналыг авч Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Мөн нийтээр тэмдэгдэх баярын ердүүдтэй холбоотой ажил, амралтын зохицуулалт хийхтэй холбоотой танилцуулга, мэдээллийг бэлтгэсэн. Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлстэй холбоотой хууль тогтоомжийн талаар мэдээлэл, зөвлөмж авахаар утсаар холбогдсон иргэд, байгууллагуудыг мэдээлэл, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллав. Мөн ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин бодох төрийн албан хаагчдын	100%

	санхүүгийн ажил хуудад чиглэл, зөвлөмж мэдээлэл өгөх, холбогдох мэдээллийг бэлтгэнэ.					цалин хөлстэй холбоотойгоор ирүүлсэн 89 албан бичиг, өргөдөлд холбогдох хариуг хүргүүлсэн.	
9.	Арга хэмжээ 1.9 Төрийн албан хаагчдын зайнаас, цахимаар, цагаар ажиллах журам боловсруулан батлуулна.	үйл ажилл агааны зардал	Шийдвэр бүхий баримт бичиг /тоо/	0	2	“Гэр бүлд ээлтэй хөдөлмөрийн харилцаа ажлын байр” судалгаа /Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3/ хийх, төрийн албан хаагч, аж ахуйн нэгж, байгууллагад зайнаас, цахимаар ажиллах журам, хөдөлмөрийн дотоод журам боловсруулах аргачлал, зөвлөмжийг боловсруулан батлуулах ажлыг 2025 оны 07-10 дугаар сард НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран зохион байгуулахаар төлөвлөөд байна.	90%
10	Арга хэмжээ 1.10 Төрийн зарим албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт оруулна.	Улсын төсөв 15.6 тэрбум төгрөг	Шийдвэр бүхий баримт бичиг /тоо/	0	1	- Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолд Засгийн газрын 2025 оны 38 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан. - Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, цалин хөлсний талаарх судалгаа, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Төрийн албаны реформ хийх асуудлыг судалж, санал дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг/-т хүргүүлсэн.	100%
11	Арга хэмжээ 1.10 “Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн	үйл ажилл агааны зардал	Тушаал-1	Журмын төсөл боловсруулах, санал авах	Журмын төслийг батлуулах	“Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж тус журмаар зохицуулж байгаа харилцааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгахаар шийдвэрлэв	100%

	журмын төсөл боловсруулна.						
12	Арга хэмжээ 1.12 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо болон аймаг, дүүргийн зөвлөлийн дүрмийг боловсруулан батлуулах	үйл ажилл агааны зардал	Тогтоол-1	Дүрмийн төслийг боловсруулах	Дүрмийн төслийг батлуулах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн боловсруулж Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний 05 дугаар тогтоолоор батлуулав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо болон аймаг, дүүргийн зөвлөлийн дүрмийг боловсруулан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны 2025 оны 02 дугаар сарын 11-ний 01 дүгээр тогтоолоор батлуулан салбар хороо болон зөвлөлд хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
13	Арга хэмжээ 1.13 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах, шалгалт авах журмыг боловсруулж, батлуулна.	үйл ажилл агааны зардал	Тушаал-1	Журмын төсөл боловсруулах, санал авах	Журмын төслийг батлуулах	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах журам”-ын төслийг боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/130 дугаар тушаалаар батлуулсан. Улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 02/1825 тоот албан бичгээр хүргүүлээд байна.	100%
14	Арга хэмжээ 1.14 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний III-чуулган зохион байгуулахад хамтран ажиллана.	үйл ажилл агааны зардал	Чуулган	Чуулган зохион байгуулахтай холбоотой гоор бэлтгэл ажлыг зохион байгуулахад хамтран оролцох	Чуулган зохион байгуулсан байна.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний III чуулганыг Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар, ХАБЭМТ-тэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Төрийн ордны их танхимд МУ-ын ерөнхийлөгчийн ивээл дор амжилттай зохион байгууллаа. Чуулганд МҮЭХ, МАОЭНХ, МҮХАҮТ, ХХҮЕГ, НДЕГ, яамдын ХАБЭА-н салбар хороо, 21 аймаг, 9 дүүргийн ХАБЭА-н зөвлөл, эрдэмтэн зөвлөхүүд зэрэг нийт 800 гаруй төлөөлөл оролцлоо.	100%
15	Арга хэмжээ 1.15 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2025” арга	үйл ажилл агааны зардал	Арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээнд холбогдох асуудлаар оролцох	Арга хэмжээг зохион байгуулс	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2025” арга хэмжээг Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан уриатай уялдуулан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөгжил: Хиймэл оюуны хэрэглээ ба цахимжилт” уриан дор 2025 оны 04 дүгээр сарын 02-ны	100%

	хэмжээг зохион байгуулахад ХАБЭМТ-тэй хамтран ажиллана.		д хамтран ажиллах		ан байна.	өдрөөс эхлэн төлөвлөгөө гарган ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг олон нийтэд түгээн ажиллалаа. Аяныг төлөвлөсөн хугацаанд нь амжилттай зохион байгуулав	
16	Арга хэмжээ 1.16 “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” сайдын албан даалгаврыг батлуулж, холбогдох талуудад хүргүүлнэ.	үйл ажилл агааны зардал	Албан даалгавар	Албан даалгавры г боловсруу лах	Батлуу лах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлэх хүрээнд “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар албан даалгаврыг батлуулж, яамдын салбар хороо, аймаг дүүргийн зөвлөл, ХХҮЕГ, ХАБЭМТ, МАОЭНХ, МҮЭХ, МҮХАҮТ-т 2025 оны 02 дугаар сарын 02/382 тоот албан бичгээр хүргүүлэв.	100%
17	Арга хэмжээ 1.17 Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талын хамтын ажиллагааг бэхжүүлнэ.	үйл ажилл агааны зардал	Салбарын хэлэлцээрийн тоо, салбар, аймаг, нийслэлийн хороодын тоо /өссөн дүнгээр/	10	20	Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг Ерөнхий сайдын захирамжаар батлуулахаар захирамжийн төсөл, танилцуулгыг ЗГХЭГ-т хүргүүлж, 2025 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн Ерөнхий сайдын 38 дугаар захирамжаар Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг батлуулсан. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны Улсын хэлэлцээрийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийг Үндэсний хорооны тогтоолоор байгуулж, МАОЭНХ, МҮЭХ, яамны хамтарсан ажлын хэсэг 3 удаа хуралдаж, яамдууд, харьяа газруудаас биелэлтийг нэгтгэн дүгнэхэд 84 хувийн биелэлттэй дүгнэгдсэн ба талуудад тайланг хүргүүлсэн байна. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэж, Үндэсний хорооны хурлыг зохион байгуулж, хурлаас гаргасан Үндэсний хорооны тогтоолын төслийг боловсруулах, албажуулах, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, Үндэсний хороотой холбоотой албан тоотуудыг боловсруулан хүргүүлэн ажиллаа. Үндэсний хорооны хурал зохион байгуулах бэлтгэл ажлуудыг гүйцэтгэж, хурлын	100%

						хэлэлцэх асуудлыг батлуулан, хуралд оролцогсдод хурлын товыг мэдэгдэх, тухай бүрд хурлыг зохион байгуулсан болно. Шаардлагатай материалуудыг хувилах, хэвлэх, тараах, мэдээлэл бэлтгэх, хурлаас гарсан шийдвэр, тогтоол, албан тоотыг хууль эрх зүйн болон албан бичгийн стандарт ханган ажилллаа.	
18	Арга хэмжээ 1.18 Салбарын хамтын хэлэлцээрүүдийг хууль тогтоомжийн дагуу бүртгэн, мэдээллийн санг бүрдүүлнэ.	үйл ажилл агааны зардал	Салбарын хэлэлцэрийн тоо, салбар, аймаг, нийслэлийн хороодын тоо /өссөн дүнгээр/	0	1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааг хангах, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлуудыг Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Засгийн газар салбарын хэлэлцээрүүдэд тусган хамтран ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дах хэсэгт заасны дагуу салбарын хамтын хэлэлцээрийг хянан бүртгэх, хуульд нийцээгүй тохиолдолд бүртгэхээс татгалзах эрхтэй. Одоогийн байдлаар салбарын 14 хэлэлцээрийг хуулийн дагуу хянан бүртгэн баталгаажуулсан байна. Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 22 хороо, аймаг, нийслэлийн 22 хамтын хэлэлцээр, салбарын 14 хэлэлцээр байгуулагдан ажиллаж байна. Нийгмийн түншлэлийн хүрээнд улс, аймаг, орон нутгийн нийгэм, эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, иргэд, хөдөлмөрчдийн орлого, амьжиргааны түвшинг дээшлүүлэхтэй холбогдсон олон асуудлууд хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын болон хөдөлмөрлөх эрхийн асуудлуудыг нийгмийн түншлэлийн хоёр болон гурван талт хэлэлцээрээр баталгаажуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	100%
19	Арга хэмжээ 1.19 Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороодын гишүүдийг чадавхжуулах, урамшуулал олгох	үйл ажилл агааны зардал, ОУБ	Төрийн нарийн бичгийн даргын тушаал	0	2	Баянгол, Хан-Уул, Сүхбаатар дүүрэг, Баян-Өлгий Говь-Алтай, Сүхбаатар, Өмнөговь, Завхан, Хөвсгөл, Булган, Өвөрхангай, Төв, Хэнтий, зэрэг аймаг, дүүргийн нийт 13 Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хорооны 2025 оны 05 дугаар сарын 15-ны 01 дүгээр тогтоолоор шинэчлэн батлуулав. Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах хорооны гишүүдийн урамшуулал, хөдөлмөрийн зуучлагч,	100%

					хөдөлмөрийн арбитрчдын урамшууллыг олгохоор 21 аймаг, 9 дүүргийн ХХҮГ, хэлтээс мэдээлэл нэгтгэхээр 2025 оны 06 дугаар сарын 16-ны 02/1967 албан бичгийг хүргүүлэв. Мэдээг нэгтгэн Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар гишүүдийн урамшуулал олгогдоно.	
20	Арга хэмжээ 1.20 Хөдөлмөрийн сонирхлын маргааны статистик мэдээллийг нэгтгэх	-	-	ХНХС-ын 2024 оны 29 дүгээр тушаал	Хөдөлмөрийн сонирхлын маргааны тоог 2024 оны нэгтгэн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны 02/272 тоот албан бичгээр, дахин сайжруулан 2025 оны 04/528 тоот албан бичгээр тус тус Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн. Тус мэдээллийг 1212.mn –д байршуулсан болно. https://www.1212.mn/mn/statistic/statcate/573055/table-view/DT_NSO_0400_42V1	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлстэй холбоотой гадаад, дотоодын сургалтад хамрагдана.	Холбогдох сургалтад хамрагдсан байна.		Холбогдох сургалтад хамрагдсан байна.	Яам болон Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан чадавхижуулах сургалтад хамрагдав. Мөн хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой бусад улс орны туршлагыг судласан.	2025.01.01-2025.06.31	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХХЦХХ-ийн дарга
(Албан тушаал)

Б.Нарангарав
(2025 оны 6 сарын үсэг)

2025 оны 6 дугаар сарын
18-ны өдөр
(Огноо)



ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА,
ЦАЛИН ХӨЛСНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Б.НАРАНГАРАВЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Нэгжийн нэр: Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Цалин хөлс, ажил, амралтын цагтай холбоотой бодлого, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, зохицуулалтыг боловсронгуй болгох”-ыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 1.1 Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангана.	60	10	70	70
2.	Арга хэмжээ 1.2 Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж боловсруулж батлуулна.	60	10	70	70
3.	Арга хэмжээ 1.3 Жаргалтай өвөл буюу Happy January хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулна.	54	9	63	63
4.	Арга хэмжээ 1.4 Аж ахуйн нэгж, байгууллагад зайнаас, цахимаар ажиллах хөдөлмөрийн дотоод журам боловсруулах аргачлал, зөвлөмжийг боловсруулан батлуулна.	54	9	63	63
5.	Арга хэмжээ 1.5 Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр болон хөдөлмөрийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах хүрээнд холбогдох сургалт зохион байгуулна.	60	10	70	70
6.	Арга хэмжээ 1.6 Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотой тооцоо, судалгааг хийж, холбогдох тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	60	10	70	70
7.	Арга хэмжээ 1.7 Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөлөлд төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр тусгах арга хэмжээний тооцоо, судалгааг хийж Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлнэ.	60	10	70	70
8.	Арга хэмжээ 1.8 Ажилтны ажил, амралтын цаг, цалин				

	хөлстэй холбоотой тогтоол шийдвэрийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагын хүний нөөц болон санхүүгийн ажилтнуудад чиглэл, зөвлөмж мэдээлэл өгөх, холбогдох мэдээллийг бэлтгэнэ.	54	10	64	64
9.	Арга хэмжээ 1.9 Төрийн албан хаагчдын зайнаас, цахимаар, цагаар ажиллах журам боловсруулан батлуулна.	55	5	60	60
10.	Арга хэмжээ 1.10 Төрийн зарим албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт оруулна.	60	10	70	70
11.	Арга хэмжээ 1.10 "Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмын төсөл боловсруулна.	60	10	70	70
12.	Арга хэмжээ 1.12 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо болон аймаг, дүүргийн зөвлөлийн дүрмийг боловсруулан батлуулах	60	10	70	70
13.	Арга хэмжээ 1.13 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах, шалгалт авах журмыг боловсруулж, батлуулна.	60	10	70	70
14.	Арга хэмжээ 1.14 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний III-чуулган зохион байгуулахад хамтран ажиллана.	60	10	70	70
15.	Арга хэмжээ 1.15 "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2025" арга хэмжээг зохион байгуулахад ХАБЭМТ-тэй хамтран ажиллана.	60	10	70	70
16.	Арга хэмжээ 1.16 "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" сайдын албан даалгаврыг батлуулж, холбогдох талуудад хүргүүлнэ.	60	10	70	70
17.	Арга хэмжээ 1.17 Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талын хамтын ажиллагааг бэхжүүлнэ.	54	10	64	64
18.	Арга хэмжээ 1.18 Салбарын хамтын хэлэлцээрүүдийг хууль тогтоомжийн дагуу бүртгэн, мэдээллийн санг бүрдүүлнэ.	60	10	70	70
19.	Арга хэмжээ 1.19 Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороодын гишүүдийг чадавхжуулах, урамшуулал олгох	60	10	70	70
20.	Арга хэмжээ 1.20 Хөдөлмөрийн сонирхлын маргааны статистик мэдээллийг нэгтгэх	60	10	70	70
Дундаж оноо:				68.2	68,2

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
		1	2	3
1.	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, цалин хөлстэй холбоотой гадаад, дотоодын сургалтад хамрагдана.	95	14.25	14.25
Дундаж оноо			14.25	14.25

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
		1	2
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	7	7
3.	Асуудал шийдвэрлэх	7	7
4.	Хариуцлагатай байдал	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		7	7

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
		1
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	68.2
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14.25
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7.0
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8.0
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	-
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын		97.45

оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

ХБГ-ын дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

ИХ.Тамир/
(албан хаагчийн нэр)

2025-06-13
..... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:

ХХЦХХ-ийн дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

И.Б.Нарангарав/
(албан хаагчийн нэр)

2025.06.19
..... (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

.....
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

И.В.Тувшинжаргал/
(албан хаагчийн нэр)

2025.06.20
..... (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

.....
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

И.В.Тувшинжаргал/
(албан хаагчийн нэр)

2025.06.20
..... (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

И.Д.Мөнхзул/
(албан хаагчийн нэр)

2025.06.20
..... (огноо)

